



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 574

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 17,101,652.00 (арван долоон сая нэг зуун нэг мянга зургаан зуун тавин хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг Багануур дүүргийн шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Батсайхан, Багануур дүүргийн шүүхийн Тамгын газрын дарга Б.Эрдэнэбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн  
 844 дугаар тогтоолын хавсралт

**БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Хөрөнгө шилжүүлэн өгөх байгууллага	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэр лэсэн он	Ашиглан тэд орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	Истана 50-70 УБС, №119016, KPDGBDH81P126826	2001	2013	255909	17,101,652.00	17,101,652.00	-	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар
<b>НИЙТ ДҮН</b>									
						17,101,652.00	17,101,652.00		
						(арван долоон сая нэг зуун нэг мянга зургаан зуун тавин хоёр)	(арван долоон сая нэг зуун нэг мянга зургаан зуун тавин хоёр)		